



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/59

Улаанбаатар хот

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Шагналын журам шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51 дүгээр зүйлийн 51.1.3, 61 дүгээр зүйлийн 61.1.1, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дүрмийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Захиргааны зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн шагналын журам”-ыг нэгдүгээр, “Шагналд нэр дэвшигчийн анкетын загвар”-ыг хоёрдугаар, “Хүндэт тэмдэг”-ийн загварыг гуравдугаар, “Хүндэт тэмдэг”-ийн үнэмлэхийн загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Тус журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга /Б.Баатарцогт/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/13 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Х.ЭРДЭМ-УНДРАХ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын
2024 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн
А/59 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, хууль зүйн шинжлэх ухааны судалгаа болон иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд идэвх зүтгэл гарган үр бүтээлтэй ажиллаж, онцгой амжилт гаргасан ажилтан, зүтгэлтэн, хуульч, төрийн албан хаагчийг шагнахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх, тус хүрээлэнгийн гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх үйл хэрэгт идэвх зүтгэл гаргаж бодитой хувь нэмэр оруулсан төрийн болон төрийн бус байгууллага, тэдний ажилтан, хуульч, хамт олон, аж ахуйн нэгж, гадаад улсын иргэнийг уг шагналаар шагнаж болно.

Хоёр. Шагналын төрөл

- 2.1. Хүрээлэнгийн шагнал нь хоёр төрөлтэй байна. Үүнд:
 - 2.1.1. “Хүндэт тэмдэг”;
 - 2.1.2. “Хүндэт өргөмжлөл”
- 2.2. Энэхүү тушаалын хавсралтаар тэмдэг болон үнэмлэхийн загварыг батална.

Гурав. Шагнал олгох болзол

- 3.1. Монгол Улсын хууль зүйн салбарыг хөгжүүлэх, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, сурталчлах үйл хэрэгт үр бүтээлтэй ажилласан, өндөр үр чадвартай эрх зүйч, хуульч болон хууль зүйн салбарт дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан албан хаагч, иргэнийг “Хүндэт тэмдэг”-ээр, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан албан хаагч, иргэнийг “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнана.
- 3.2. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн нэрэмжит шагналаар шагнахдаа дор дурдсан шалгуурыг харгалзан үзнэ. Үүнд:
 - 3.2.1. Албан үүргээ тогтмол, гүйцэтгэлийн өндөр түвшинд биелүүлж, идэвх санаачилга гаргасан байдал;
 - 3.2.2. Төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг чандлан сахисан байдал;
 - 3.2.3. Ажил мэргэжлийн үр чадвар, үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин;
 - 3.2.4. Онцгой амжилт.
- 3.4. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, хууль зүйн шинжлэх ухааны судалгаа болон иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд идэвх зүтгэл гарган үр бүтээлтэй ажиллаж, онцгой амжилт гаргасан

ажилтанд хугацаа харгалзахгүйгээр “Хүндэт тэмдэг” болон “Хүндэт өргөмжлөл” шагналыг олгож болно.

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

- 4.1. Шагналд нэр дэвшүүлж байгаа иргэн, албан хаагч нь энэхүү журмын гуравдугаар бүлэгт заасан болзлыг хангасан байна.
- 4.2. Шагнуулахаар нэр дэвшүүлсэн хүмүүсийг тодорхойлохдоо дор дурдсан материалыг бүрдүүлнэ:
 - 4.2.1. Хамт олны хурлын тэмдэглэл;
 - 4.2.2. Батлагдсан загварын анкет /цээж зураг 3x4/;
 - 4.2.3. Ажил байдлын тодорхойлолт;
 - 4.2.4. Холбогдох байгууллага, албан тушаалтны санал;
 - 4.2.5. Ажлын үр дүнгийн үзүүлэлт /бүтээлийн жагсаалт гэх мэт/.
- 4.3. Дээрх материал, холбогдох баримт бичгийг бүрдүүлж, энэхүү журмын 5.1-д заасан тэмдэглэлт баяр ёслолын өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө тус хүрээлэнгийн Хүний нөөцийн мэргэжилтэнд цахим болон цаасан хэлбэрээр ирүүлнэ.

Тав. Шагналыг шийдвэрлэх, олгох

- 5.1. Шагналыг нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт дараах өдрүүдэд олгоно:
 - 5.1.1. Үндсэн хуулийн өдөр;
 - 5.1.2. Хуульчдын өдөр;
 - 5.1.3. Үндэсний их баяр наадам;
 - 5.1.4. Байгууллагын тэмдэглэлт, тэгш ойн өдөр;
 - 5.1.5. Шинжлэх ухааны ажилтны өдөр;
 - 5.1.6. Хамтрагч байгууллагын тэмдэглэлт ойн өдөр.
- 5.2. Шагналд нэр дэвшигчийн материалыг тус хүрээлэнгийн Хүний нөөцийн мэргэжилтэн хүлээн авч, энэхүү журмын 4.2-т заасан материалыг хянан, бүрдүүлбэрийг хангуулж, холбогдох саналаа Захиргааны зөвлөлд танилцуулна.
- 5.3. Шагнах асуудлыг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал тушаал гарган шийдвэрлэж, хувийн дугаар бүхий “Хүндэт тэмдэг”-ийн үнэмлэх болон “Хүндэт өргөмжлөл” дээр гарын үсэг зурж баталгаажуулна.

Зургаа. Дагалдах мөнгөн шагнал

- 6.1. Хүндэт тэмдгээр шагнахад 200,000 хүртэлх төгрөг, Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 100,000 хүртэлх төгрөгийн мөнгөн шагналаар тус тус шагнаж урамшуулж болно.
- 6.2. Энэхүү дагалдах мөнгөн шагналыг тухайн хүнийг шагнуулахаар тодорхойлсон байгууллага хариуцна.

Долоо. Шагналын мэдээллийн сан

- 7.1. Хүрээлэн нь шагнагдсан хүмүүсийн мэдээллийг цахим мэдээллийн санд шагналын төрөл, огноогоор төрөлжүүлэн, бүрдүүлж ашиглана.
- 7.2. Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт хөдөлгөөнийг тус хүрээлэнгийн Хүний нөөцийн мэргэжилтэн хариуцан хөтөлж, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга хяналт тавина.

Найм. Бусад зүйл

- 8.1. Хүрээлэнгийн ажилтнуудаас тэмдэглэлт үйл явдал, ойг тохиолдуулан төрийн дээд цол, одон, медаль, салбарын шагналаар шагнуулахаар тухайн нэгжийн хурлаас дэвшүүлсэн ажилтнуудын материал, хурлын тэмдэглэлийг Захиргаа, удирдлагын хэлтсээс судлан үзэж шаардлага хангасан бол Захиргааны зөвлөлд танилцуулан холбогдох журамд заасны дагуу нэр дэвшүүлэн уламжилж, байгууллагын цахим санд бүртгэнэ.
- 8.2. Шагналд зарцуулагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж байна.


--- о0о ---

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын
2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн
А/59 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн шагналд
нэр дэвшигчийн анкетын загвар

1. Ургийн овог:
2. Эцэг /эх/-ийн нэр:
3. Өөрийн нэр:
4. Төрсөн огноо:
5. Регистрийн дугаар:
6. Хүйс:
7. Төрсөн хот/аймаг, сум:
8. Одоогийн харьяалал:
9. Боловсрол:
10. Ажилладаг салбар:
11. Мэргэжил:
12. Ажил эрхэлсэн байдал /он дарааллаар/:



Зураг
3x4

д/д	Ажлын газрын нэр	Ажилласан хугацаа /он дарааллаар/	Эрхэлсэн ажил, албан тушаал
1.			
2.			
3.			

13. Ажилласан нийт хугацаа ... /жил/ үүнээс тухайн салбарт жил, тухайн хөдөлмөрийн хамт олны дотор жил.

14. Шагнагдсан байдал:

д/д	Шагналын нэр	Шагнагдсан он
1.		
2.		
3.		

15. Шагнуулах үндэслэл:

.....

16. Ямар шагналаар шагнуулах:

17. Хамт олны саналын хувь:

Захирал /дарга, эрхлэгч/...../нэр, гарын үсэг, тамга, тэмдэг/

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын
2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн
А/59 дүгээр тушаалын 3 дугаар хавсралт




“ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ИЙН ЗАГВАР



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын
2024 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн
А.59 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт



“ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ИЙН ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР

	<p>Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн ХҮНДЭТ ТЭМДЭГ</p>
<p>ҮНЭМЛЭХ № ...</p> <p>Тэмдгийн зураг</p> <p>Дугаар ...</p> <p>20.. оны .. дүгээр сарын ...-ны өдөр</p>	<p>..... ТАНАА</p> <p>Монгол Улсын хууль тогтоомжийн тогтолцоо, хэрэгжилт, уялдаа, үр нөлөөг шинжлэх ухааны үндэстэй судлах, боловсронгуй болгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийн бүртгэл, системчлэл, хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа явуулах үйлсэд оруулсан хувь нэмрийг тань үнэлж “Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн “ХҮНДЭТ ТЭМДЭГ”-ээр шагнаж үнэмлэх олгов.</p> <p>ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ</p>